ЗГХЭГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2020 онд тус газрын үл хөдлөх хөрөнгө, түүний ашиглалт, хамгаалалтын байдалд шалгалт хийж үндсэн 5 чиглэлээр зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

“Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар” УТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг үндэслэн 5.629,085.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 112,581.7 мянган төгрөгөөр тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар” УТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 494,776.4 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний	Эцсийн	Өөрчлөлт
	үлдэгдэл	үлдэгдэл	
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	9,525.9	4,094.1	(5,431.8)
Авлага	6,439.7	102,657.0	96,217.3
Урьдчилгаа (урьдчилж гарсан зардал)	-	54,845.5	54,845.5
Бараа материал	1,109,330.9	1,181,054.8	71,723.9
Үндсэн хөрөнгө	28,673,249.0	27,961,117.7	(712,131.3)
Нийт хөрөнгө	29,798,545.5	29,303,769.1	(494,776.4)
Өр төлбөр	5,671.3	47,567.0	41,895.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	29,792,874.2	29,256,202.1	(536,672.1)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	29,798,545.5	29,303,769.1	(494,776.4)

Авлага дансны үлдэгдэл 102,657.0 мянган төгрөг болж 96,217.3 мянган төгрөгөөр өссөн нь Сангийн яамнаас буцаан авах татаас санхүүжилтийн 11,167.0 мянган төгрөг, ЗГХЭГ-ын барьцаа хөрөнгийн дансанд төвлөрүүлсэн 91,490.0 мянган төгрөгийг тус тус бүртгэсэн нь шалтгаалжээ.

Урьдчилгаа дансны үлдэгдэлд “Шинэ монгол гэр” ХХК-д 5 ханатай гэрийн урьдчилгаанд төлсөн 3,200.0 мянган төгрөг, “Хандок инженеринг” ХХК-д хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих, өргөх буулгах механизм, лифтийн сэлбэгийн урьдчилгаанд төлсөн 46,651.5 мянган төгрөгийг тус тус бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,181,054.8 мянган төгрөг болж 71,723.9 мянган төгрөгөөр өссөн. Үүнд аж ахуйн материал 32,409.0 мянган төгрөг, хангамжийн материал 21,051.3 мянган төгрөг, бэлэн бүтээгдэхүүн 7,389.1 мянган төгрөг, бичиг хэргийн материал 5,369.8 мянган төгрөг, бусад бараа материал 5,504.7 мянган төгрөгөөр тус тус өссөн нь шалтгаалжээ.

Тайлант хугацаанд ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2020 оны 32 дугаар тушаалаар ЗГХЭГ-аас 3,303.9 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авч, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын даргын 2020 оны А/47 дугаар тушаалаар 30 нэрийн 4,104.6 мянган төгрөгийн үнэ бүхий ашиглалтын шаардлага хангахгүй болсон хангамжийн материалыг акталж данс бүртгэлээс хассан.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 27,961,117.7 мянган төгрөг болж 712,131.3 мянган төгрөгөөр буурсан.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2020 оны 753 дугаар тогтоолоор 8,030.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий тоног төхөөрөмжийг ЗГХЭГ-т балансаас балансад шилжүүлж, ТӨБЗГ-ын 2020 оны А-1/2342 дугаар албан бичгээр 210,909.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар авсан 211,007.4 мянган төгрөг, болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 16,500.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 47,567.0 мянган төгрөг болж 41,895.7 мянган төгрөгөөр өссөн нь Төрийн ордны цахилгааны төлбөр 24,151.8 мянган төгрөг, дулааны төлбөр 2,098.6 мянган төгрөг, ТӨБЗГ-т төлөх түрээсийн төлбөрийн 11,167.1 мянган төгрөг, “Эссайн” ХХК-д төлөх смарт ариутгагч хаалганы төлбөрийн 2,000.0 төгрөг, Засгийн газрын автобаазад төлөх 1,402.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 29,256,202.1 мянган төгрөг болж 536,672.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн бууралтаас шалтгаалжээ.

“Төр, засгийн үйлчилгээ аж ахуйг эрхлэх газар” УТҮГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,026,741.1 мянган төгрөгөөр буюу 23.3 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны болон төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 349,982.7 мянган төгрөгөөр буюу 6.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, хангамж, урсгал засварын зардлууд байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2020 оны төсвийн төслийг 5,381,908.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 883,966.4 мянган төгрөгөөр бууруулж 4,497,942.3 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төлөвлөлтийг үндэслэлгүйгээр хэт өндөр дүнгээр төлөвлөж байгааг харуулж байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,497,942.3 мянган төгрөгийн төсөв баталснаас САГ-2021/349/СТА-ТШЗ

4,322,942.3 мянган төгрөгийг улсын төсвөөс, 175,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,286,915.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 84,750.0 мянган төгрөг, нийт 4,371,665.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд бүрэн зарцуулсан байна. Тайлант онд Ковид-19 цар тахлын хатуу хөл хорио тогтоож, хурал цуглааны үйл ажиллагааг зогсоосны улмаас Төрийн ордны заал танхимын түрээсийн орлого тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 126,277.2 мянган төгрөг буюу 97.2 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой зардлыг 78,908.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг 11,981.6 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 35,330.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас хүлээн авсан 365,269.7 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 278,000.0 мянган төгрөг, нийт 643,269.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшилд 57,369.9 мянган төгрөг, хангамж бараа ммтериалын зардалд 154,468.7 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 431,765.5 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 5.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлогын 235,692.8 мянган төгрөгийг бүртгэсэн нь төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөлтийг үндэслэлгүй хийснээс шалтгаалжээ.

Энэхүү зөрчлийг аудитын илрүүлэлт болон менежментийн захидалд тусгасан болно.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 164 мэдээллээс хугацаандаа оруулсан 162 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Мөн цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 26 гүйлгээний мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2		2				100.0
Нийт дүн	2		2				100.0

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,021,630.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,429,637.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,756.6 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 324,508.5 мянган төгрөгийн зөрчилд болон Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн талаар 2 албан шаардлага хүргүүлж, 262,727.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнасан дүнг Шалгах баланс болон Ерөнхий журналын дүнтэй тулган үзэхэд нэмэлт орлогын дансанд бүртгэсэн 643,269.7 мянган төгрөгийн орлогыг Мөнгөн гүйлгээний тайланд үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих гэдгээр тайлагнасан.
2. Батлагдсан төсвийн дагуу их засварын санхүүжилтийн орлогын 786,368.1 мянган төгрөгийг Санхүүгийн үр дүнгийн тайланд “Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт” гэсэн ангиллаар тайлагнасан боловч Мөнгөн гүйлгээний тайланд зохих ангиллаар тайлагнаагүй байсныг тус тус залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 591,992.6 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 4,756.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 324,508.5 мянган төгрөгийн зөрчил болон шилэн данстай холбоотой асуудлаар 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Аудитаар тус газрын ажиллагсдын 2020 оны ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын тооцоог шалгаж үзэхэд Хавсралтад дурдсан 50,644,583.45 төгрөгийн тэтгэмжийн орлогод нийт 4,756,605.15 төгрөгийн албан татварыг ногдуулаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21 дүгээр зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн Акт тогтоох.

2. Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ-ын даргын 2020 оны Б/02 дугаар тушаалаар ажилтнуудын албан тушаалын цалинг 20 хувиар нэмэгдүүлэн тогтоож, нийт 324,508,481.00 төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар

тогтоолын 9 дүгээр хавсралт (*Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ*)-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Тус газрын шилэн дансны 2020 оны мэдээллийг харилцах дансны гүйлгээ болон мөнгөн хөрөнгийн журналын бичилттэй тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 26 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалттай нийцэхгүй, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллага, иргэдэд цахим мэдээллийг дутуу хүргэх эрсдэл үүсгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 262,727.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

ТӨБЗГ-ын шийдвэрийн дагуу 2019, 2020 онд акталсан хөрөнгийг хэрхэн шийдвэрлэсэн байдал, акталсан үндсэн хөрөнгийн дүнгээр дахин үнэлгээний нэмэгдэл дансанд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тус газрын хангамжийн бараа материалын дансанд 5 нэрийн нийт 27,034.7 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан байна.

Энэ нь УСНББОУС 17-д Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах шинжтэй биет зүйлсийг хэлнэ. а) “Бараа, үйлчилгээний үйлдвэрлэл буюу нийлүүлэлтэнд ашиглах, бусдад түрээслэх, эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглах зорилгоор эзэмшиж байгаа; ба, б) нэгээс дээш тайлант үед ашиглагдахаар хүлээгдэж буй” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд бараа материал, үндсэн хөрөнгийн дүн, элэгдлийн зардал буруу дүнгээр илэрхийлэгдэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Хангамжийн бараа материалын дансанд бүртгэсэн 5 нэрийн нийт 27,034.7 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх.

Тус газрын НБББББ-т үндсэн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлтийн талаар тусгаж, бараа материал, үндсэн хөрөнгийн тайлан тооцоонд бүртгэлээр тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

НБББББ-т нэмэлт өөрчлөлт оруулж зохицуулна.

2. Нэмэлт санхүүжилтийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлогын 235,692.8 мянган төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан.

Энэ нь төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас орох орлогын төлөвлөлтийг үндэслэлгүй хийснээс шалтгаалсан байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн төлөвлөлт буруу хийгдэж, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг зарцуулах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Цаашид төсвийг өмнөх жилүүдийн гүйцэтгэлд үндэслэн бодитой төлөвлөж, санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төрийн үйлчилгээнүүдийн зардлын төсөв нь манай газрын жилийн урсгал төсөвт тусгагддаггүй, ЕТГ, УИХ, ЗГХЭГ, ҮАБЗ-ийн жилийн урсгал төсөвт тусгагдаж батлагдсан байдаг. Иймээс төрийн дээд байгууллагуудын албан хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлсэн гүйцэтгэлээр холбогдох тооцоо, баталгаажсан баримтыг үндэслэн төлбөрийн нэхэмжлэх сар бүр өгч нэмэлт санхүүжилтийн орлого бүрддэг.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	“Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар” УТҮГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			САГ-2021/349/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	“Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар” УТҮГ		мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2020 онд ажиллагсад олгосон тэтгэмж, урамшууллын 50,644.6 мянган төгрөгийн орлогод нийт 4,756.6 мянган төгрөгийн албан татварыг ногдуулаагүй.	4,756.6	Акт	Дарга Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Ж.Тамир Г.Нэрж Д.Ганчимэг
2	Тус газрын ажилтнуудын албан тушаалын цалин, нэмэгдлийг шинэчлэн батлахдаа “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралтаар баталсан цалингийн сүлжээг үндэслэлгүйгээр 20 хувиар нэмэгдүүлэн 2020 онд нэр бүхий 208 хүнд нийт 324,508.5 мянган төгрөгийг илүү тооцож олгосон.	324,508.5	Албан шаардлага	Дарга Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Ж.Тамир Г.Нэрж Д.Ганчимэг
3	Тус газрын шилэн дансны 2020 оны мэдээллийг харилцах дансны гүйлгээ болон мөнгөн хөрөнгийн журналын бичилттэй тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 26 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна.	-	Албан шаардлага	Дарга Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Ж.Тамир Г.Нэрж Д.Ганчимэг
4	Тус газрын хангамжийн бараа материалын дансанд 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 5 нэрийн нийт 27,034.7 мянган төгрөгийн үнэ бүхий үндсэн хөрөнгийг бүртгэж тайлагнасан.	27,034.7	Зөвлөмж	Дарга Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Ж.Тамир Г.Нэрж Д.Ганчимэг
5	Нэмэлт санхүүжилтийн дансанд үндсэн үйл ажиллагааны орлогын 235,692.8 мянган төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан.	235,692.8	Зөвлөмж	Дарга Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Ерөнхий нягтлан бодогч	Ж.Тамир Г.Нэрж Д.Ганчимэг
ДҮН		591,992.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 24

№ 14/АД160056

Улаанбаатар хот

САГ-2021/349/СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ-ын даргын 2020 оны Б/02 дугаар тушаалаар ажилтнуудын албан тушаалын цалинг 20 хувиар нэмэгдүүлэн тогтоож нэр бүхий 208 хүнд нийт 324,508,481.00 төгрөгийн цалинг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт (Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ)-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн захирагч нь цалин хөлстэй холбоотой тушаал шийдвэр гаргахдаа хууль тогтоомжийг мөрдөж ажиллах, зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ-ын дарга Ж.Тамир, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Г.Нэрж, Ерөнхий нягтлан бодогч Д.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ДАВААДОРЖ

Г.ЮРА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2021\0224auditin 2-R Gazar4.Docx

001081002



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 24

№ 15/А0160056

Улаанбаатар хот

СЭГ-2021/349/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус газрын шилэн дансны 2020 оны мэдээллийг харилцах дансны гүйлгээ болон мөнгөн хөрөнгийн журналын бичилттэй тулган шалгахад цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлагын нийт 26 гүйлгээний мэдээллийг оруулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.2.9-д заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх,
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ-ын дарга Ж.Тамир, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Г.Нэрж, Ерөнхий нягтлан бодогч Д.Ганчимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ДАВААДОРЖ

Г.ЮРА

9006109
0019120396

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherig\Alban Shaardlaga\2021\0224\auditin 2-R Газар1.Docx

001080993



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2021 оны 02 дугаар сарын 24

№ 05/А0160056

Улаанбаатар хот

Саяг-2021/349/СТА-ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар УТҮГ-ын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитаар тус газрын ажиллагсдын 2020 оны ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын тооцоог шалгаж үзэхэд Хавсралтад дурдсан 50,644,583.45 төгрөгийн тэтгэмжийн орлогод нийт 4,756,605.15 төгрөгийн албан татварыг ногдуулаагүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд зааснаар тодорхойлсон орлогын дүнд 10 хувиар тооцож, албан татвар ногдуулна", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "үнэн зөв байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. "Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар" УТҮГ-ын ажиллагсдад олгосон тэтгэмж урамшууллын орлогод ногдох хувь хүний орлогын албан татварын нийт 4,756,605.15 төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг "Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар" УТҮГ-ын дарга Ж.Тамир, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга Г.Нэрж, Ерөнхий нягтлан бодогч Д.Ганчимэг нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
"БАЯН СУВАРГА АУДИТ" ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
А.ДАВААДОРЖ

Г.ЮРА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2021\0224auditin 2-R Gazar1.Docx

001090382